



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ  
АХЛАХ СУРГУУЛЬ  
ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/94

Улаанбаатар хот

Г

Г

“Байгаль-Эх лицей ахлах сургуулийн багш,  
ажилтны ажлын үр дүнгийн урамшуулал, ур чадвар,  
нэмэгдэл тооцох журам” шинэчлэн батлах тухай

Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.2.1 дахь заалт, дүрмийн 3.4.1, 3.4.4, 3.5.2 дахь заалтууд, захирлын дэргэдэх зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

4. “Байгаль-Эх лицей ахлах сургуулийн багш, ажилтны ажлын үр дүнгийн урамшуулал, ур чадвар, нэмэгдэл тооцох журам”-ыг хавсралтаар баталж 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

5. Тушаал гарсантай холбогдуулан захирлын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн A/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгаль-Эх лицей ахлах сургуулийн багш, ажилтны ажлын үр дүнгийн урамшуулал, ур чадвар, нэмэгдэл тооцох журам”, захирлын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн A/71 дүгээр тушаалыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс тус тус хүчингүй болгосугай.

6. Тушаалыг нийтэд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавихыг сургалтын менежер (Б.Булгамаа)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

П.ТҮВШИНТӨР



201900241



Захирлын 2019 оны 11 дугаар сарын 21-ны өдрийн 11/11 дугаар тушаалын хавсралт.

БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ АХЛАХ СУРГУУЛИЙН БАГШ,  
АЖИЛТНЫ АЖЛЫН ҮР ДҮНГИЙН УРАМШУУЛАЛ,  
УР ЧАДВАР, НЭМЭГДЭЛ ТООЦОХ ЖУРАМ

Зорилго:

Багшийн хүүхэд нэг бүрийг төлөвшүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлэх, бүтээлч үйл ажиллагаагаар хүрсэн үр дүнг үнэлэх.

1. Улирлын ажлын үр дүнгийн урамшуулал,  
ур чадварын нэмэгдлийг тооцох:

Үндэслэл:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол (4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4.3, 4.5 дахь хэсгүүд)
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол (3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.1, 4.2, 4.3, 4.5 дахь хэсгүүд)
- БШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хамтарсан 362/112/183 дугаар тушаал (ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт)
- БШУ-ны сайдын 2013 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/293 тушаал (ЕБС-ийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам)

Шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Ойлголт	Гүйцэтгэлийн үзүүлэлт
1	Төлөвшил	1. Оролцоо /5 оноо/ 2. Дадал хэвшил /10 оноо/ 3. Зан чанар /5 оноо/	1. Хүүхэд нэг бүрийг суралцах үйл болон сайн дурын, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзэл, боломжийг бүрдүүлсэн байдал; 2. Хүүхэд нэг бүрийн сургуулийн болон нийгмийн орчны хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа байдал, эрмэлзэл; 3. Хүүхэд нэг бүрийн нийгмийн орчинд өөрийгөө зөв авч явах, илэрхийлэх, бусадтай зөв харилцах /ажилсаг, эвсэг, тусархаг/ зан чанар төлөвшүүлсэн байдал;
2	Хүүхэд бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц амжилт /20 оноо/	1. Ахиц /10 оноо/ 2. Амжилт /10 оноо/	1. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахицын түвшин; 2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын улирлын амжилтын үнэлгээ;

3	Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал /20 оноо/	Хүүхэд нэг бүрт заяагдсан төрөлхийн олон талт боломж, чадавхийг нээн хөгжүүлэх	1. Авьяасыг судалсан, нээсэн байдал /5 оноо/ 2. Авьяасыг хөгжүүлсэн байдал /урсан, чаддаг болсон зүйлийн тоо, чанар/; /15 оноо/
4	Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж /20 оноо/	1. Сурагчийн 2. Эцэг эхийн 3. Бусад оролцогчийн	Санал асуулгын үр дүн: 1. Багшийн хүүхэд нэг бүрийн хөгжилд үзүүлсэн дэмжлэг /15 оноо/ 2. Багшийн мэргэжлийн ёс зүй /5 оноо/
5	Эрүүл мэндийн байдал /20 оноо/	1. Эрүүл чийрэг байдал 2. Эрүүл харилцаа 3. Эрүүл аюулгүй орчин	1. Хүүхдийн эрүүл мэндийг сайжруулсан байдал; /5 оноо/ 2. Эрүүл харилцааг бүрдүүлэхэд оруулсан хувь нэмэр; /5 оноо/ 3. Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд оруулсан хувь нэмэр; /10 оноо/

Үр дүнгийн урамшил олгох:

Ажлын үнэлгээгээр 70-аас дээш оноо буюу “Сайн үнэлгээ авах нь багш улирлын мөнгөн урамшил авах үндэслэл болно.

70-80 оноо авсан бол 10%

81-90 оноо авсан бол 15%

91-100 оноо авсан бол 20%

Үр чадварын нэмэгдэл олгох:

Ажлын үнэлгээгээр 80-аас дээш оноо буюу “Хангалттай сайн” үнэлгээ авах нь багш үр чадварын нэмэгдэл авах үндэслэл болно.

#### Үр чадварын нэмэгдэл авах үзүүлэлт, хувь

№	Үзүүлэлт	Нэмэгдлийн хувь
1	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас багшийн ажлыг үнэлж дүгнэхээр гаргасан журам шалгуур үзүүлэлтийн биелэлтээр 80-аас доошгүй оноо авсан байх Сургалтын технологийн шийдэл, хөгжил, төлөвшлийн ажлын арга барилд гаргасан ахиц	5%
2	Сурагчдын сурлагын амжилтын хагас жил тутмын үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний үзүүлэлтүүдийн зөрүү нь 10 хувиас илүүгүй байх	10%
3	Багш нь дүүрэг, нийслэл, улсын төрөлжсөн олимпиадад медальт байранд шалгарсан бол 5 хүртэл хувь	Дүүрэгт - Шагналт болон тусгай байр - 2% - Медальт байр - 3% Нийслэлд - Шагналт болон тусгай байр - 3% - Медальт байр - 4% Улсад - Шагналт болон тусгай байр - 4% - Медальт байр - 5%

		<p><b>Дүүрэгт</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шагналт болон тусгай байр - 2%</li> <li>- Медальт байр - 3%</li> </ul> <p><b>Нийслэлд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шагналт болон тусгай байр - 3%</li> <li>- Медальт байр - 4%</li> </ul> <p><b>Улсад</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шагналт болон тусгай байр - 4%</li> <li>- Медальт байр - 5%</li> </ul>
4	Суралцагчид нь дүүрэг, нийслэл, улсын төрөлжсөн олипиадад медальт байранд шалгарсан бол 5 хүртэлх хувь	

## 2. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх

Үндэслэл:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”
- БСШУ, НХХ, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”
- МУИС-ийн захирлын 2019 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан “Монгол улсын их сургуульд профессор, багш ажиллуулах журам”

Сургуулийн захиргааны шийдвэрээр

- Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох,
- Заавар, журам бусад баримт бичиг боловсруулах,
- Бусад үүрэгт ажлын хөлсийг Захирлын тушаалаар олгоно.

Энэ заалтад уралдаан, тэмцээн зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг тооцохгүй болно.